

Д.Цэрэнпил, ШУ-ны доктор, профессор  
МУИС, ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн багш

## **Шилжилтийн үр дүн, сургамж, тулгамдсан асуудлууд**

*Энэ ажилд, зах зээлийн эдийн засагт шилжиж буй арав гаруй жилийн үр дүн, түүнд нөлөөлсөн хүчин зүйлд дүгнэлт хийсэн болно. Шилжилтийн үйл явцад тохиолдож буй бэрхшээлүүдээс үүдэн хүн ам, тэдний нийгмийн баталгааг бүрдүүлэх явдал нийгмийн хурц асуудал болон тавигдах болсон төдийгүй одоогийн манай эдийн засгийн өсөлтийн хурдац нь дээрх асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлж чадахгүй байгаа юм. Энэ талаар судлаач тодорхой баримтуудаар үнэлэлт, дүгнэлт хийж, цаашид анхаарах шаардлагатай зарим асуудлаар өөрийн санал бодлоо илэрхийлэн тавьсан болно.*

### **1. Гараа, сэргэлт, бууралт.**

**Шилжилтийн гараа.** Монголын эдийн засаг, нийгмийн бүх хүрээнд шинэчлэл хийгдэж, зах зээлийн харилцааг тууштай нэвтрүүлж байна. Шинэчлэлийн үйл явц, үр дүнг үнэлэхэд хийгдэж байгаа өөрчлөлтүүд нь хоёрдмол шинж төлөвтэй байна. Энэ нь:

*Нэгд, Төвлөрсөн төлөвлөгөөт удирдлагын механизмыг маш түргэн эвдэх, эдийн засагт захиргаадлын зохицуулалтыг хязгаарлах.*

*Хоёрт, Зах зээлийн зүй ёсны элементүүдийг эрчимтэй нэвтрүүлж, эдийн засгийн хөгжлийн үйл явц нээлттэй ба хаагдмал хоёр хэмжүүрээр тодорхойлогдож байна.*

Шилжилтийн эхний жилүүдийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийн ерөнхий зорилт нь:

- эдийн засгийг ардчилах, /төрийн өмчийн хувьчлал, үнэ, эдийн засгийн гадаад үйл ажиллагааг оролцуулан/;
- хямралаас гаргаж макро эдийн засгийг тогтворжуулах /санхүү, төсөв, мөнгө зээлийн тогтолцоог эрүүлжүүлэхээс эхлэн/;
- зах зээлийн харилцаанд шилжих нөхцлийг бүрдүүлэх /хууль эрх зүй, эдийн засгийн нөхцөл/ зэрэг юм.

Өнгөрсөн хугацаанд төрийн өмчийг хувьчилж, төсөв, татвар, мөнгө зээлийн тогтолцоог шинэчилж, үнэ, гадаад эдийн засгийн харилцааг чөлөөлж, валютын хөрвөх ханшинд шилжиж, аж ахуйчлалын хэв шинжийн төрлөөр хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгож, эдийн засагт зах зээлийн бүтэц, механизмыг нэвтрүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлсэн. Ялангуяа өмч, капиталыг хуваарилах, дахин хуваарилах үйл явцад оролцох бүх иргэдийн нийгэм эдийн засгийн боломжийг хангах, нийгмийн баталгааны үндсийг бүрдүүлэх, хувийн секторыг дэмжиж бэхжүүлэх, үр бүтээмжтэй ажиллах нөхцлийг бий болгох талаар нааштай алхамууд хийгдсэн. Өнгөрсөн хугацаа нь эдийн засгийн уналт, харьцангуй тогтворжих хандлага хосолсон маш төвөгтэй үе байлаа.

А/ Гүнзгий хямрал, их уналтын үе: (1990-1993 он) Энэ хугацаанд :

- эдийн засаг түргэсэх хурдацтайгаар унаж ДНБ-ий үйлдвэрлэл жил тутам дунджаар 6 хувиар буурч,

- хүн амын амьдралын түвшин 40 гаруй хувиар огцом доошилж, хүнсний болон бусад нэн чухал шаардлагатай барааны хүрэлцээ хангамж багасч, бараа материалын улсын нөөц барагдсан;
- ажилгүйдэл, ядуурал бодит үзэгдэл болж нийгмийн хурц асуудлыг бий болгов;
- санхүү, мөнгөний тогтолцоо гүнзгий хямарч, төгрөгийн ханш унаж, валютын ханш өсөж, үнэ, тариф огцом нэмэгдэж, инфляци жолоодлогогүй хэмжээнд хүрсэн.

Б/ Сэргэлтийн үе: (Энэ үе 1994 оноос эхэлсэн). ДНБ, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч санхүү, мөнгө-зээлийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх, өмч хувьчлал явуулах гол арга хэмжээ авагдаж, үнэ, төгрөг, валютын ханш харьцангуй тогворжиж, инфляци буурав. Гэхдээ эдийн засгийн өсөлт бүрэн тогтворжиж, нийгмийн хурц асуудал шийдвэрлэгдсэн гэж үзэж ер болохгүй, харин ч улам ээдрээтэй болсон. 1996-1999 онд эдийн засаг, нийгмийн амьдралд чанарын дорвитой өөрчлөлт гарсангүй, үндэсний үйлдвэрлэлийн уналт, санхүү мөнгө-зээлийн секторын хямрал үргэлжилсээр, улс төрийн хямрал ч улам гүнзгийрсэн.

*Хямрал, уналтын шалтгааны тухай ихээхэн маргаантай үзэл бодол байдаг. Нэг хэсэг нь өнгөрсөн түүхээс уламжилж ирсэн хямралын шалтгаан гэдэг. Нөгөө хэсэг нь гэнэт бүхнийг нурааж Монголын эдийн засгийг элгээр нь хэвтүүлж зах зээлийн хөрснөөс шинээр эхлүүлэх гэсэн үзэл баримтлалаар урьдах ололтоо үгүйсгэж, шинэчилсэн удирдлага зохицуулалтын механизмаа бүрдүүлээгүйн дээр зах зээлийн зохион байгуулалтын мөн чанарын тухай мэдлэг дутмаг, ямар ч дадлага туршлагагүй, үүний зэрэгцээ хэт хөөрүү сэтгэлгээнд хөтлөгдсний гай хэмээн үздэг.*

Эдийн засаг, нийгмийн хямрал, огцом уналтыг зөвхөн шилжилтийн эхэн үеийн онцлог гэж шууд үзэж болохгүй, энд урьдаас уламжлагдан ирсэн үр дагавар холбоотой нь тодорхой.

Шилжилт, шинэчлэлийн гараа нь макро, микро эдийн засгийн түвшний хөгжлөөр тактик, стратегийн чиг баримтлал, цаг хугацааны хязгаар байхгүйгээр эхэлсэн.

Монголд улс төр, эдийн засгийн шинэчлэлийг зэрэг явуулсан нь нэг талаас зайлшгүй ач холбогдолтой үйл явдал, нөгөө талаас улс төрийн байдал эдийн засагтаа туйлын хүчтэй нөлөөлдөг. Хэрэв тогтворгүй байвал эцэст нь эдийн засгаа сүйрлийн ирмэгт аваачдаг жамтай. Түүний наад захын нөлөөллийг манай орон чамлалтгүй амссан. Эдийн засгийн бодлогын чиг баримтлал, суурь асуудалд улс төрийн тэргүүлэх хүч, тодорхой бүлгийн ашиг сонирхлын үүднээс хандаж байсан нь зарим үед шилжилт, шинэчлэлийн зоримог эхлэлийн эрчийг саармагжуулсан. Зах зээлийн мөн чанар, арга зүйг бүрэн танин мэдрээгүй суурь дээр бүтээлч биш зохион байгуулалтаар эдийн засгийн хаагдмал шинжтэй өөрчлөлт нилээд хийгдсэн. Энэхүү хаагдмал өөрчлөлтөд өмнөх үед ба өнөөгийн шинэчлэлийн үед өндөр албан тушаал дээр ажиллаж байсан "элит" бүлэг хүмүүс гол үүрэг гүйцэтгэснийг ард түмэн гадарлах болсон. Тэд эзэмшилдээ өмч, капиталын (мөнгөн хөрөнгийн) дахин хуваарилалт, бөөгнөрүүлэлт хийж "зах зээлийн биш хэлбэрээр өөрийн болгох" эргүүлж залруулахад нэн хүнд журам тогтоход хүргэсэн. Ийм байдал даамжирвал төрийн болон зах зээлийн зохион байгуулалтын харилцан уялдааг

сулруулж ирээдүйг бүдгэрүүлэх аюулд хүргэхийн дээр гаж үзэгдлийн үндсийг тавина.

Улс оронд авилгал, архидалт, эмх замбараагүй байдал, хуйвалдаан, хууль хяналт, татвараас зугтах, төсөв, өмч хөрөнгийг хувийн ашиг сонирхолд зарцуулах, идэж ашиглах явдал газар авсан. Зарим олиггүй үзүүлэлтээр манай орон дэлхийд дээгүүр байр эзлэх болсон. Ийм гаж үзэгдэл үйл явдлууд нь эдийн засаг, нийгмийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг.

Санхүү, мөнгө-зээлийн тогтолцоо эрүүлжиж чадахгүй байв. Эдийн засаг, нийгмийг хямралаас гаргах, тогтворжуулах, зах зээлийн харилцаанд шилжихэд санхүү, мөнгө-зээлийн механизм шийдвэрлэх хүчин зүйл мөн. Иймээс төсөв, татвар, банкны тоголцооны шинэчлэлийг эхэлж хийсэн. Монгол улс бага эдийн засагтай, дотоод хуримтлал байхгүй, ямагт санхүүгийн нөөцийн хомсдолтой байдаг. Шилжилтийн эхэн ба дунд үед улсын санхүүгийн чадвар нэн хүндэрсэн. Үүний зэрэгцээ санхүү, мөнгө-зээлийн тогтолцооны удирдлага, зохион байгуулалтыг хэтэрхий үймүүлж мэргэжлийн менежментийн роль, ач холбогдлыг бууруулж зөвхөн "улс төр"-өөр удирдах гэж оролдсон нь улам их төвөг учруулсан. Судалгааны үр дүнг үндэслэн энэ үеийн санхүү, мөнгө-зээлийн тогтолцооны хүндрэлийн талаар дараах хэдэн багц дүгнэлтийг хийж болох юм. Үүнд:

1. Үндэсний эдийн засгийн нэгдмэл чанарыг хангах, нийгэм эдийн засгийн үйл явцыг интеграцчилах чадвар бүхий зах зээлийн механизмын элементүүд, суурь бүтцийн бүрдэлт түүний нөхөн үйлдвэрлэлийн чиглэмжийг эхнээс нь төрийн нарийн бодлого, зохицуулалттай боловсруулж шат дараалалтай хэрэгжүүлээгүй явдал санхүү, мөнгөний бодлого, түүний хэрэгжилтэнд нилээд хүндрэлийг бий болгосон. Хэдийгээр дотоодын нийт бүтээгдэхүүн, төсвийн орлого зарлага, мөнгөн гүйлгээний хэмжээ ерөнхий дүнгээрээ өсөж байсан болон эдийн засгийн макро, микро түвшинд санхүүгийн чадвар бүхэлдээ доройтсон. Өрийн сүлжээ эдийн засгийг бүхэлд нь хамарч, төлбөрийн балансын алдагдал ихэсч, арилжааны олон банкны заримыг нь зохион байгуулалттайгаар дампууруулж, хөрөнгийн бирж дээр өмч хувьчлалын нэрийн дор санхүүгийн дамлал явагдсан.
2. Төсвийг хамгаас их улс төржүүлсэн нь түүний орлого, зарлагын тогтолцоо, бүтэц, үр ашигт сөргөөр нөлөөлсөн. Орлого нь үнийн өсөлт, зах зээлийн конъюнктураас шууд хамаарагдах боллоо. Эдийн засгийн бодит секторын үйл ажиллагааны үр дүнгээс орох татварын (орлогын татвар) орлогын хувийн жин /1995 оныхоос/ бараг 2 дахин буурч, үнээр дамжин эцсийн хэрэглэгчдээс авах татварын орлогын хувийн жин тэр хэмжээгээр нэмэгдэв. Энэ бол татварын тогтолцооны дутагдал. Энэ нь нэг талаас үндэсний үйлдвэрлэл унаж, орлого эрс буурсан, нөгөө талаас хэрэглээний эрэлтийг гадны бараагаар зонхилон хангаж, арилжаа наймааны орлого нэмэгдэж байгааг гэрчилнэ. Импорт өсөж, экспорт буурч балансын алдагдал хэд дахин нэмэгдэв. Төсвийн зарлагын хангамж хүрэлцээгүй хөрөнгийн ашиглалтын үр ашиг нэн хангалтгүй байгаа нь олон удаагийн шалгалтаар илэрч байна.
3. Улсын төсвийн механизм /засгийн газрын ерд үйлчлэх, төлөөлөн орлох/ банкны гол үйлчилгээ болох зээл нь капиталыг өөрийн болгох, дахин хуваарилахад баримжаалж, харин эдгээрийн идэвхжил нь улсын эдийн засгийг тогтворжуулахад бүрэн чиглэгдэхгүй байлаа. Чухамдаа 2000

оныг хүртэл хугацаанд Төв банк нь засгийн газарт /богино хугацааны зээл олгох, үнэт цаас бондын дийлэнхийг байршуулах/ үндсэн зээлдүүлэгч болж байв.

4. Банк 1990 оны сүүлч хүртэл мөнгөний хатуу бодлого явуулж, мөнгөний нийлүүлэлтийг хязгаарлах хүрээнд ашигт ажиллагааны түвшин доогууртай аж ахуйн нэгжүүд, ялангуяа шинэ тутам эхлэн ажиллуулж байгаа дунд аж ахуйнууд зээл авахад бэрхтэй, авсан зээл нь өндөр хүүтэй байснаас дарамтанд ордог байв.

Төлбөр-мөнгөний эргэлтийн ихэнх хувь санхүү мөнгөний зохицуулалтын нөлөөний хүрээнээс гарсан явдал нь мөнгө-зээл, төсвийн бодлогод болон үнэ, валютын ханшны тогтворжилтод сөрөг нөлөө үзүүлэх магадлал ихтэй болсон. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 90 гаруй хувь банкнаас гадуур гүйгдэж, хугацаандаа төлөгдөөгүй зээлийн өрийн үлдэгдэл хэт ихсэж, арилжааны томоохон банкнууд дампуурсан. Энэ нь санхүү /мөнгөний харилцаанд балансжилтанд чухал нөлөө бүхий механизм/ мөнгөн гүйлгээний зохицуулалт болох төлбөр тооцооны харилцаа ба бодит секторын хүрээний мөнгөн гүйлгээний байдалд удаан хугацаанд төдийлөн анхааралтай хандаагүйн үр дагавар юм. Эцэстээ төлбөр-мөнгөний эргэлтийн бодит хэрэгцээ нийт мөнгөний хэмжээг бүрдүүлэх үйл явцын хооронд уялдаа зохицолдоо хангалтгүй байдалд хүрсэн. Үүний улмаас аж ахуйн нэгжүүдийн өр төлбөрийн өсөлт, нийт мөнгөний хөдөлгөөний хооронд ихээхэн зөрүү үүссэн.

5. Үндэсний эдийн засаг "бүхэлдээ төлбөрийн чадваргүй" байдалд орсон. Энэ нь эдийн засгийн тогтворгүйжилт, түүний нөхөн үйлдвэрлэлийн чадавхийн доройтлын нэг гол шалтгаан болж байгаа юм. Төлбөрийн чадваргүйдэл нь улсын төсвийг оролцуулан эдийн засгийн бүх хүрээг шууд ба тойруугаар бүрэн хамарсан. Энэ нь өмч хөрөнгө, капиталын удирдлага, хяналт султай нөхцөлд "элит"-үүдийн хооронд түргэвчилсэн дахин хуваарилалт явуулах шалтаг болсон. Ард түмэн нь угаасаа ядуу, эдийн засаг нь санхүүгийн нөөцийн чадвар муутай манай орны хувьд үнэ, ялангуяа суурь үнийг гэнэт чөлөөлсөн явдал хэдийгээр зах зээлд шилжихэд чухал нөхцлийн нэг мөн боловч бүх нийтээрээ төлбөрийн чадваргүйтэхэд хүчтэй нөлөөлсөн.

Монголын эдийн засгийн бүх хүрээнд төлбөрийн чадвар доройтоход нөлөөлсөн шалтгаанууд нь:

- эргэлтийн хөрөнгийн хүрэлцээгүй, банкны зээлжүүлэлт хязгаарлагдмал үед үнэ эрс өссөний үр дагавар болох төлбөрийн чадваргүйдэл;
- мөнгөний эмиссийн баримжаалал бүхий мөнгө зээлийн бодлогын монетор чиглэл;
- өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийнхээ хэрэгцээг улсын төсөв, төвлөрсөн хөрөнгө оруулалтаар хангуулж байсан аж ахуйн нэгжүүд өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллахаар төсөв, татварын шинэ механизм, хатуу бодлогод шилжсэн;
- банк бодит секторын зээлжүүлэлтийг хязгаарлан санхүүгийн зах зээл, хөрөнгийн бирж дээрх өмчийн арилжаанд голчлон баримжаалах үйл ажиллагаа явуулж байснаар аж ахуйн нэгжүүдийн зээлийн эрсдэлийг ихсэж, санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн;
- суурь салбаруудын бүтээгдэхүүний үнийн өсөлтийн үед эцсийн хэрэглэгчдийн (хүн амын дийлэнх нь арга буюу эрэлтээ хязгаарлахад хүргэв.) төлбөрийн чадварын хязгаарлалтын ихсэлт нь нэг талаар

үнийн нэмэгдэлтийн туйл, нөгөө талаас зардлын өсөлтийн нөхцлийг бүрдүүлэв.

- аж ахуйн үнийг бууруулах зорилгоор хувьчлагдаж байгаа аж ахуйн нэгжийн өртгийг болон тэдний ажлын санхүүгийн үр дүнг бууруулах хандлага, тохиолдол бий болсон.

## 2. Эдийн засаг санхүүгийн өнөөгийн байдал

Санхүүгийн секторын ахиц: Монгол улсын эдийн засаг 2001 оны байдлаар макро түвшний зарим үзүүлэлтээр өсөлт бууралттай байгаа боловч чанарын тодорхойлолтоор ерөнхийдөө сайжрах төлөвтэй байна. Зарим үзүүлэлтийн өсөлтийн байдлыг сүүлийн онуудаар товч харуулбал:

Үзүүлэлтүүд	1996	1997	1998	1999	2000	2001
Хүн амын өсөлт %	1,5	1,4	1,5	1,4	1,0	1,0
ДНБ-ний өсөлт %	2,4	4,0	3,5	3,2	1,1	
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт %	-2,0	4,4	3,3	1,7	5,6	11,8
ХАА бүтээгдэхүүний өсөлт %	4,7	4,8	3,1	4,2	-16,8	
Инфляцийн түшин %	44,6	20,5	6,0	10,0	8,1	11,2
Ажилгүйдэл/мян хүн/	55,4	63,7	49,8	39,8	38,6	40,3
Гадаад худалдааны балансын алдагдал/сая \$/	-26,6	-16,8	-155,6	-154,5	-148,4	-169,6
Төсвийн алдагдал/мян ₮/	-48,4	-65,1	-102,2	-98,2	-62,7	-50,4

Эх үүсвэр: ҮСГ, "Монгол улсын эдийн засаг, нийгэм 2001 онд" статистикийн эмхтгэл, 2002

Монгол улс хүн төвтэй эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхээр үндсэн хуульдаа тунхаглан заасан. Хүн ам, тэдний нийгмийн баталгааг бүрдүүлэх асуудал төр засгийн анхаарлын төвд байгаа юм.

Сүүлийн жилд хүн амын өсөлтийн хурд саарах хандлагатай байна. Үүний нөгөө талаар ажилгүйдэл, ядуурал нийгмийн хурц асуудал болон тавигдах боллоо.

Эдийн засгийн онолд хүн амын нэг хувийн өсөлтөд ДНБ 2-4 хувь өсөж байвал нийгмийн нөхөн үйлдвэрлэлээ хангах боломжтой гэсэн баримжаалал байдаг. Энэ үүднээс үзвэл манай эдийн засгийн өсөлтийн хурдац түүнийг хангах боломж бүрдээгүй байна.

Сүүлийн жилд манай оронд улс төрийн байдал харьцангуй тогтворжиж, эдийн засгийн дотоод гадаад аятай нөхцөл, боломжийн улмаас эдийн засагт чанарын ахиц гарч байна. Хэдэн жил үргэлжилсэн ган зуд цаг агаарын таагүй нөхцөл нилээд аймагт тохиолдож мал олон саяар хорогдож, газар тариалангийн үйлдвэрлэл буурсны улмаас ХАА-н салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл унаж, энэ нь ДНБ -ний өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

Харин аж үйлдвэр, үйлчилгээний салбар, санхүүгийн секторт нааштай үр дүн гарч байна. Үндэсний үйлдвэрлэлийг сэргээх арга хэмжээ авсан үр дүнд аж үйдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл сүүлийн хоёр жилд 5,6-11,8 % өсөж үүний дотор боловсруулах үйлдвэрлэл 22,7 % өсөж байна. Энэ салбар ерөнхийдөө тогтворжих хандлагатай боллоо. Цаашид эрдэс, түүхий эдийн чадавхи дээрээ түшиглэн хөгжих сайхан ирээдүйтэй юм.

Төсвийн байдал харьцангуй сайжирч байна. 2000-2001 оны төсвийн гүйцэтгэл суурь үзүүлэлтийг ерөнхийд нь дээшлүүлэх чиглэлээр хэрэгжлээ. Үр дүн нь төсвийн орлого, зарлага өсөж, татварын орлого төлөвлөснөөс давж биелэн, урсгал төсөв 50 гаруй тэрбум төгрөгийн ашигтай нийт төсвийн алдагдал 50.4 тэрбум төгрөг болон буурч ДНБ-ний 4 хувьтай тэнцэхүйц боллоо. Төсвийн санхүүжилт ялангуяа нийгмийн үйлчилгээний хүрээнд цалин, тэтгэвэр цаг хугацаандаа өгөгддөг болов. Энэ хоёр жилд засгийн газрын 140 шахам тэрбум төгрөгийн дотоодын хуримтлагдсан өрийг барагдуулах ажил хийгдэж, одоо засгийн газар бараг өргүй. Мөн 17 аймаг өргүй болжээ.

Банкны тогтолцооны санхүүгийн байдал аажмаар сайжирч байна. Сүүлийн хоёр жилд банкны өөрийн капитал нэмэгдэж, дотоод зээлийн хэмжээ, гадаад цэвэр актив, хүн амын хадгаламж өслөө. Арилжааны банкуудын санхүүгийн чадвар сэргэж, эрсдэл нь буурч Капитрон, Интер, Менатеп зэрэг шинэ банк байгуулагдсаны зэрэгцээ банк бус санхүүгийн байгууллагуудын /Одоо 34 байгаа/ үйл ажиллагаа идэвхжиж эхэлсэн нь эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлж байна. Арилжааны банкуудын нийт актив 360 тэрбум төгрөг болж ДНБ-ний 35 хувь орчим боллоо. Ард иргэд банкинд итгэх итгэл нэмэгдэж, тэдний хадгаламж ихээхэн өслөө. Иргэдийн төгрөгийн хадгаламж 2001 онд 130 орчим тэрбум төгрөг болж 1999 оныхоос хоёр дахин, гадаад валютын хадгаламж 87 тэрбум төгрөг болж 50 хувиар нэмэгдлээ. Монгол банкин дах Валютын цэвэр нөөц 163 сая ам долларт хүрсэн. Банк зээлээр үндэсний үйлдвэрлэл, хувийн секторыг дэмжих үйл явц эрс нэмэгдлээ. Дотоодод 249,0 тэрбум төгрөгийн зээл олгосны 84 хувийг хувийн секторт ногдож байна. Засгийн газар 2001 онд зээл бараг аваагүй. Эдийн засаг санхүүгийн хүрээнд гарч буй ахицтай талд дэлхийн орчин үеийн даяарчлал өсөн нэмэгдэж байгаа үйл явц ялангуяа олон улсын санхүүгийн зах зээлийн өргөжилт түүний урсгал манай оронд нэмэгдэж байгаа аятай нөхцөл эерэг нөлөө үзүүлж байна.

Гадаадын зээл тусламж: Шилжилт эхэлснээс хойш 2 тэрбум ам долларын зээл буцалтгүй тусламж авч ашиглаад байгаагийн 1,1 тэрбум нь зээл, 900 сая ам долларын буцалтгүй тусламж байна. Ашигласан зээлийн үлдэгдлийн багцыг авч үзвэл 92,6 хувь нь хөнгөлттэй зээл, 5,9 хувь нь санхүүгийн /ОУВС-ын/ хөтөлбөрийн зээл, 1,5 хувь нь арилжааны зээл байна. Оны үечлэлээр зээлийн хэмжээг авч үзвэл, 1990-2001 он хүртэл нийт зээлийн хэмжээ 1148,6 сая доллар, үүнээс 1990-1992,07 хугацаанд 336.7 сая доллар, 1992,07-1996,07 хугацаанд 525.4 сая, 1996,07-2000,07 хугацаанд 224.3 сая, 2000,07 хугацаанаас хойш 63.2 сая байна.

2001 онд 330 сая долларын зээл тусламж, үүний 185 сая ам доллар нь хөнгөлттэй зээл юм. Нийт хөнгөлттэй зээлийн 371,6 сая долларынх нь хоёр талын хөнгөлттэй, 372,8 сая долларын олон талын хөнгөлттэй, 89.6 сая

долларын хөтөлбөрийн, 71,3 сая зээл арилжааны зээлүүд байна. Гадаад зээлийн 81 хувийг дотооддоо дамжуулан зээлдүүлээд байгаа юм.

Гадаадын зээлийн ашиглалт, эргүүлэн төлөх явдал нэн хангалтгүй байна. Дамжуулан зээлдүүлсэн зээлүүдээс 1991 оноос өнөөдрийг хүртэл дөнгөж 60 орчим сая ам долларыг буцааж аваад байна. Энэ хугацаанд засгийн газар зээлдэгчдийн нэрийн өмнөөс 322 сая ам долларын хүү болон үндсэн өрийг төлжээ. Төлөх хугацаа болсон зээл жилээс жилд нэмэгдэнэ. Дамжуулан зээлдүүлсэн 83 зээлийн зээлдэгч тодорхойгүй болсны 65 нь 1990-1992 онд олгосон зээлүүд юм.

Манай улс гадаадын зээл тусламж авч ашиглах явдал өнөөгийн зайлшгүй шаардлага юм. Харин түүнийг авах үндэслэл, чиглэл, ашиглалтыг сайжруулах нь нэн чухал болж байна.

Гадаадын хөрөнгө оруулалт -бол манай орны эдийн засгийн хөгжлийг хангах нэг чухал хүчин зүйл юм. Манайд 70-д орны хөрөнгө оруулалт бүхий 2070 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Нийт 600 сая ам долларын хөрөнгө оруулахаар бүртгүүлсэн. Зөвхөн 2001 оны 25,3 сая ам. долларын хөрөнгө оруулалттай 353 компани бүртгүүлсэн нь урьд жилүүдийнхээс нилээд их хэмжээтэй байна. Энэ нь цаашдаа өргөжих төлөвтэйг харуулаж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд 2000 онд улсын төсөвт нийт 40-өөд тэрбум төгрөгийн татвар төлсөн нь нийт татварын орлогын 14,2 хувийг эзэлж байна. Төсөвт орох орлогын хэмжээ жил тутам нэмэгдэх төлөвтэй байна. Экспортын үйлдвэрлэлийн 18,3 хувийг гаргаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтанд томоохон байр эзэлж байгаа орнууд :


БНХАУ	22,8 %
БНСУ	9,2 %
Япон	8,3 %
АНУ	5,5 %
ОХУ	5,0 %
Болгар	4,5 %

Гадаадын хөрөнгө оруулалтыг салбарын байршилтаар үзвэл :

Геологи, уул уурхай	21,6
Хөнгөн үйлдвэр	13,2
Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	7,7
Барилга	6,4
Худалдаа, нийтийн хоол	5,5
Бусад	5,7

Санхүүгийн секторын бэрхшээл, сөрөг нөлөөлөл: Санхүүг эрүүлжүүлэх, чадваржуулах - зүй ёсны зайлшгүй асуудал, ерөнхий өсөлт, ахиц байвч тэр нь тогтвортой биш, гол нь зах зээлийн конъюнктурийн хүчин зүйл дээр тулгуурлаж байна. Тийм ч учраас манай орны экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, ноолуур, алтны үнийн өөрчлөлттэй санхүүгийн байдал уялдаж байна.

Манай орны эдийн засаг, санхүүгийн байдалд сөрөг нөлөө үзүүлж байгаа механизмыг бүдүүвчлэн харуулвал:



Сөрөг механизмын гол нь зах зээлийн биш сектор, далд эдийн засаг, бэхжиж чадаагүй банкны тогтолцоо юм.

Зах зээлийн биш секторт алдагдалтай, үр ашиг багатай аж ахуйн нэгжүүд орно. Алдагдалтай буюу үр ашиггүй аж ахуйн нэгжүүд манайд цөөн биш байгаа. Ийм газруудын нилээд нь орлоготой боловч түүнийг янз бүрийн аргаар нуудаг. Одоо аж ахуйн нэгжүүд арилжааны нууц гэдэг нэрийн дор үнэн бодит баланс тайлан гаргахгүй байгаагаас орлогоо нуух явдал ердийн үзэгдэл болжээ. Далд эдийн засаг нь зах зээлийн биш сектортой холбоотой учир нь энэ хоёр бие биендээ нэмэгдэл болж байдаг. Далд эдийн засагт манай орны ДНБ-ны 30 гаруй хувьтай тэнцэх хэмжээний орлого бий болж байна гэсэн судалгаа байдаг. Далд эдийн засаг нь зах зээлийн биш секторын бүх шинжийг агуулж нуугдмал орлого олж байдаг.

Эдийн засаг, санхүүгийн тогтворжилт удаан үргэлжилж байгаад объектив, субъектив олон хүчин зүйл, шалтгаан нөлөөлж байна. Эдгээрийг тоймлон авч үзвэл:

1. Эдийн засгийн бодит секторын хөгжил тогтворжиж чадаагүй нь сууриасаа эхлэлтэйг харуулна. ХАА сүүлийн жилд огцом уруудлаа. Аж



- үйлдвэр харьцангуй өсөлт гарсан боловч дараах шалтгаануудаас цаашдаа нилээд бэрхшээлтэй тулгарах болно. Үүнд :
- дотоодын төлбөрийн чадвартай эрэлтийн ерөнхий өргөжилтгүйгээр үндэсний үйлдвэрлэлийн өсөлтийн боломж хязгаарлагдмал байна. Энэ нь нэг талаас гадаад зах зээлд өрсөлдөх чадвар сул, нөгөө талаас дотоод зах зээлээ гаднын бараанд эзлүүлсний улмаас үндэсний үйлдвэрлэл эндээс шахагдсан явдалтай холбоотой. Эдийн засагт аж үйлдвэрийн байр суурь доошлох төлөвтэй 1995 онд ДНБ-д 32,4 хувийг эзлэж байсан бол 2000 онд 17 хувийг эзлэх боллоо.
2. Үйлдвэрлэлийн аппаратыг түргэн шинэчлэх хөрөнгө оруулалт байсангүй. Үндсэн хөрөнгийн хоцрогдол, биет элэгдэл одоо хүртэл үргэлжилсээр байна. Харин энэ хугацаанд мэдээллийн технологийн шугам сүлжээний аятай тогтолцоо бий болов.
    - Хэрэгцээтэй зэрэгцүүлэхэд тун бага хөрнгө оруулалт, энэ нь хөрөнгө оруулалтын олон жилийн өлсгөлөнг улам лавшруулж байна. Өнөөгийн шатанд дийлэнх хөрөнгө оруулалт дэд бүтцийн салбар луу хуваарилагдаж байгаа.
    - Харьцангуй бий болсон хуримтлалыг / Зөвхөн хадгаламж 130 гаруй тэрбум төгрөг/ хөрнгө оруулалт бусад хэргцээнд ашиглах, үр ашигтай механизм байхгүй.
    - Монголд гадаадын хөрнгө оруулалтыг татах талаар аятай нөхцлийг бүрдүүлээгүйн дээр, монголын рейтинг доогуур, мөн улс төрийн байдал нөлөөлсөн. Манай орны жижиг зах зээл, эдийн засгийн ээдрээтэй байдал, авилгал, хахуульд нэрвэгдсэн удирдлагын болон хуулийн орчин жинхэнэ чадалтай хөрнгө оруулагчийг бус харин хар бизнесийн бүлгүүдийн сонирхлыг илүү татаж байгаа нь харагдаж байна.
  3. Аж ахуйн секторын санхүүгийн нөөцийн урт, богино хугацааны хэрэгцээнд баримжаалан мөнгөжүүлэлтийн түвшин их доогуур, банкны тогтолцооны үйл ажиллагаанд хэдийгээр ахиц гарч байгаа боловч арилжааны банкуудын чадваргүй байдал удаан үргэлжилсэн. 1996-2000 онд банкнаас олгосон нийт зээлд урт хугацаат зээл дөнгөж 10 хувь, эргэлтийн зээл 90 хувийг эзэлж байна. Эргэлтийн зээлийн 44 хувийг худалдаа, арилжааны хүрээнд зориулагдсан.
    - Манай оронд таваарын биет солилцоо, зээлийн борлуулалт их энэ нь эдийн засгийн мөнгөжүүлж чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь мөн. Үүний улмаас эцэстээ эдийн засагт төлбөрийн чадваргүй байдлыг улам нэмэгдүүлнэ.
  4. Төлбөрийн баланс хүнд байгаа, экспортын хэмжээ буурч, хямдарч, импортын хэмжээ ихсэн үнэтэй болж байна. Өөрөөр хэлбэл манай эдийн засаг зах зээлийн конъюнктураас их хамааралтайг батална. Экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, ноолуур, мөн алтны үнийн уналт, нефть бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамикт нөлөөлж байна.
  5. Үнэ тариф, валютын ханшны ердийн монополь байдал, төсвийн алдагдлын динамик, хүн амын бодит орлогын бууралт нь эдийн засаг болон инфляцийн цаашдын хандлагад нөлөөлх гол хүчин зүйл болно. Манайд ханшны бодлого үнэндээ хязгаарлагдмал болсон. Иймээс 0,5- 1 хувийн өөрчлөлт нийт эдийн засгийн хэмжэээнд нөлөөлнө. Ялангуяа үйлдвэрлэл, хэрэглээ, хүн амын амьжиргааны түвшинд өөрчлөлт оруулна.
  6. Эдийн засгийн өсөлтийн гол саатуулагч нь бүтцийн хямралд байгаа юм. Энд гол асуудал зах зээлийн биш сектор үр ашиггүй аж ахуйн нэгжийн

олшрол, далд эдийн засгийн бөөгнөрөл. Ихэнх аж ахуйн нэгж ялангуяа боловсруулах, олдворлох үйлдвэрлэлийн салбарт хугацаа хэтэрсэн өр төлбөр ихтэй учир нэмэгдсэн өртөг үйлдвэрлэгдэхгүй байгаа. Алдагдалтай олон нэгж байгаа. Төлбөрийн эргэлт удааширсан 6-12 сард л авлага орж ирэх жишээтэй.

7. Төсвийн бодлогыг түүний орлого зарлагын хэсэгтэй холбон авч үзье. Манай орны хүн ам тутамд тооцоолсноор төсвийн зарлага 2000 онд 171,5 мянган төгрөг, 2001 оны урьдчилсан гүйцэтгэлээр 195,2 мянган төгрөг тухайн үеийн валютин ханшаар тооцвол 2001 онд 155 ам доллар, 2001 онд 177 доллар ногдож байна. Эндээс дүгнэлт хийхэд төсвийг батлагдсан хэмжээгээр болон давуулан биелүүлсэн нөхцөлд үндэсний эдийн засгийн аюулгүйн үүднээс авч үзвэл улсын хэрэгцээний санхүүгийн хангамж нэн хангалтгүй байна. Ялангуяа хүний хөгжил, тухайлбал шинжлэх ухаан, боловсрол, эрүүлийг хамгаалах, нийгэм хангамж, халамжийн нэг хүн амд ногдох зардал улам бага байна. Төсвийн чадвар орлоготойгоо холбоотой гол нь татвар. Орлого нийт дүнгээрээ өсөж байгаа боловч орох ёстой орлогоо бүрэн оруулж чадахгүй байна. Энд олон шалтгаан бий. Тухайлбал,
  - Аж ахуйн удирдлагын түвшний соёл доогуур.
  - Татварын болон санхүүгийн бусад хууль, эрхзүйн зөрчил их, тогтворгүй олон удаа өөрчлөгддөг.
  - Татвар, зардал, орлогын бүртгэл хангалтгүй, тайлагналт сул. Үүнээс мэдээлэл хомс.
  - Бэлэн мөнгөний удирдлага алдагдсан.
  - Манай гадаадын өр зээлийн хамаарлын түвшин улам өндөржиж байгаа. Гадаад өрийг ДНБ-тэй харьцуулбал түвшин өндөр гарч байна. Өөрөөр хэлбэл энэ харьцаа нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын үүднээс дэлхийн олон улсад баримталдаг жишиг босгоос 1,5 дахин өндөр байна. Дэлхийн 200 гаруй орноор саяхан гаргасан өрийн судалгаар авч үзэхэд Монгол улс өр багатай 65 оронд багтаж байгаа боловч нэг хүнд ногдох хэмжээгээрээ эхний 6 дахь орон болж байна. 90-ээд оны эхээр авсан зээлийн үндсэн өрийг 2001 оноос төлж эхэлсэн. Энэ бол цаашдаа ДНБ-ний хуваарилалтанд өөрчлөлт оруулж, төсвийн зарлагыг нэмэгдүүлэх болно.

### **3. Цаашид анхаарах асуудал**

Сэргэлт, тогтворжуулалт, ирээдүйн бүх зорилт нь эдийн засгийн бодит салбарын хөгжил, санхүү, мөнгө-зээлийн секторын бэхжилттэй холбоотой. Улс орны эдийн засаг, санхүүгийн талаар өөрт бодогдсон зарим саналаа доор товч тодорхойлов.

1. Эдийн засагт, ялангуяа манай орны өнөөгийн шатанд төрийн хүчтэй зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Энэ бол төвлөрсөн төлөвлөгөөт үеийн захиргаадлыг бий болгоно гэсэн үг биш. Ардчилал, зах зээл нь аль эрт тогтворжсон, эдийн засгийн хөгжил, чадавхи өндөртэй орны түүхэн туршлагаас суралцах боловч шууд хуулбарлаж ер болохгүй. Тэдгээр орон дотроо тогтсон зохицуулалт, дэг журамтай.

Манай оронд эдийн засгийн тогтворжилт, өсөлт, хүн амын нийгмийн баталгааг бүрдүүлж, аж амьдралын дээшлэлтийг хангахад

баримжаалж, эдийн засаг, нийгмийн үйл явцын зохицуулалтанд төрийн ролийг өндөржүүлэх өнөөгийн эдийн засгийн шинэ бодлогын гол утга учир орших ёстой.

Манай төрийн эдийн засгийн шинэ-бодлого дэлхийн олон улсын хэмжээнд дэмжигдэх боллоо. Өнгөрсөн оны намар Америкийн гурван тэргүүлэх эрдэмтэн Д.Стиглиц, Д.Акерлоф, М.Спенс эдийн засгаар нобелийн шагнал хүртсэн. Тэд зах зээлийг бүрэн чөлөөтэй урсгалаар хөгжүүлэх нь эдийн засагт тэгш биш, хамгийн ээдрээтэй нөхцлийг бий болгодог. Иймээс эдийн засгийн, ялангуяа зах зээлийн харилцааны зохицуулалтанд төр идэвхитэй оролцохын чухлыг өөрсдийн гол үзэл санаа болгожээ. Зах зээлийн эсрэг үзэл бодолтой гэж дээрхи гурван эрдэмтэнд Нобелийн шагнал хүртээгээгүй нь мэдээж. Зохицуулалт шаардлагатай нь Азийн "бар" орнуудаас эхлээд дэлхийн олон орны хөгжлийн практикаар батлагдаж байна.

2. Эдийн засгийн өсөлтийн хамгийн чухал асуудал бол хөрөнгө оруулалт. Манайх үйлдвэрлэлийн техник, технологийн болон бүтээгдэхүүий шинэчлэл, өргөтгөл хийхгүйгээр дотоод, гадаадын зах зээл дээр өрсөлдөж чадахгүй. Үүнтэй уялдуулан:
  - Хөрөнгө оруулалтын уур амьсгал, ажил хэрэгч идэвхжилтийг аж ахуй эрхлэлтийн бүх түвшинд хөгжүүлж, дээд зэргээр дэмжиж, урамшуулах;
  - Хөрөнгө оруулалтанд томоохон аж ахуйд буй болж байгаа хуримтлал, банкуудад бий болсон хадгаламжийн нөөцийг ашиглах механизмыг боловсронгуй болгох;
  - Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө, дотоодын эх үүсвэрийг нэгдсэн зохицуулалт, хяналттай ашиглах үүднээс засгийн газрын харъяа хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк ажилуулбал илүү ач холбогдолтой;
  - Улсын хэмжээгээр үндсэн хөрөнгийн тооллого явуулж, үнэлгээг нэгдсэн журмаар цэгцлэх. Ингэснээр үндсэн капиталын зах зээлийн өртгийг тодорхойлох. Хамгийн чухал нь ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийн үндсэн капиталын бүтэц, техник, технологийн түвшинд үнэлгээ өгөх.
  - Элэгдэл хорогдлын түргэвчилсэн бодлогод шилжиж, шимтгэлийн нормыг шинэчлэх, түүнийг санд шимтгэн оруулах хатуу журамтай болгох;
  - Лизинг, хөнгөлөлттэй зээлжүүлэлтийн үндсэн дээр шинэ техник, тоног төхөөрөмжөөр үндэсний үйлдвэрлэлийг хангах;
  - Эх орондоо техник, сэлбэгийн үйлдвэрлэлийг боломжийн хэрээр хөгжүүлэх, гадаадын тэргүүний техник, технологийг өргөн нэвтрүүлэх үүнтэй гааль, татварын бодлогыг уялдуулах;
3. Манайд зах зээлийн харилцаанд хөлөө олсон, үйлдвэрлэл, санхүүгийн хувьд чадваржиж байгаа том компаниуд бий болж эдийн засагт нөлөө бүхий байрыг эзлэх боллоо. Эдгээрийн үйл ажиллагааны үр дүн нь өнөөгийн шатанд зах зээлийн конъюнктурээс хамааралтай, хэлбэлзэл ихтэй, үүний зэрэгцээ бүтээгдэхүүний үнэ, тариф үндсэндээ монополь шинжтэй, аажмаар нэмэгдэх хандлагатай боловч орлого ашиг нь доривтой тогтворжиж чадаагүй байна. Дотоод гадаадын зах зээлд байр эзэлж чадсан том аж ахуйнууд алсдаа манай эдийн засгийн гол зүтгүүр болно. Эцсийн бүтээгдэхүүний

экспортыг л нэмэгдүүлбэл эдийн засаг хөгжинө. Иймээс эх орныхоо эдийн засгийн хөгжилд тэдний хандах хандлагыг өөрчлөх, хөрөнгө оруулалтанд давуу тал, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны хувьд дээд зэргийн "ил тод" байх, төр засгийн зүгээс үзүүлэх дэмжлэг, урамшууллын механизмыг боловсронгуй болгох хэрэгтэй байна.

Түүнчлэн хувийн жижиг, дунд аж ахуйн нэгжийг төрийн цэгцтэй бодлого чиглэлтэйгээр хөгжүүлэх, дэмжлэг тусалцааг сайжруулах нь чухал. Үүнийг эдийн засгийн өсөх ирээдүйтэй чадавхи болгох. Жижиг дунд үйлдвэрлэл нь дотоодын зах зээлд хүнс, өргөн хэрэглээний зүйлийн эрэлтийг хангах, үйлчилгээг өргөтгөх, ажлын байрыг шинээр бий болгох, орон нутагт тархалт, байршил сайнтай, шинэ техник технологийг хурдан нэвтрүүлэх зэрэг олон давуу талтай. Зах зээлийн онуудын практикаас үзэхэд энэ аж ахуйг том аж ахуйтай хоршин ажиллуулах нь менежментийн үүднээс илүү зохимжтой байдаг байна.

4. Гадаадын хөрөнгө оруулалтыг өргөн нэвтрүүлэх нь чухал. Ингэхдээ:
  - Монголд татах аятай нөхцөлийг бүрдүүлэхийн дээр зохицуулалт, хяналт хийх механизм зайлшгүй шаардлагатай;
  - Гадаадын хөрөнгө оруулалтыг нэвтрүүлэх тодорхой бүс тогтоох, одоогийнх шиг хаа дуртай газраа дур зоргоороо байршиж ер болохгүй. Энэ нь эдийн засаг, нийгмийн хувьд хожим хор нөлөөтэй болно;
  - Гадаадын хөрөнгө оруулалт заавал нэгдсэн зохицуулалттай байх ёстой. Орон нутаг түүгээрээ зөвшөөрөл олгоод байгаагаас эмх замбараагүй байдал гарна;
  - Хөрөнгө оруулагч нарыг сайн судлах, гэрээ хэлцэлийг эхнээс нь зохих шаардлагын дагуу чанд хийвэл зохистой. Өөрөөр хэлбэл жинхэнэ хөрөнгө оруулагч нарыг татах нь чухал. Одоогийн байдлаар нэлээд нь түргэн хугацаанд ашиг хонжоо олох гэсэн "хар бизнес"-үүд байгааг анхаарвал зохино.
5. Манай орны эдийн засаг, нийгмийн хөгжилд гадаадын зээл тусламж чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь одоо үед үнэхээр шаардлагатай. Жил тутмын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн 60-80 хувийг эндээс хангаж байна. Зээл авч болно. Гагцхүү авсан зээлийг зориулалтын дагуу зохистой нямбай ашиглах явдал ихээхэн доголдолтой байна. Ялангуяа 1991-1996 онуудад авсан зээлийн ашиглалт нь нэн хангалтгүй байгаа. Зээлийг дотооддоо дахин зээлдүүлэхэд зээлдэгч нарыг сайтар шалгаруулах хэрэгтэй.

Манай төр, засгийн төв байгууллага зээлийг гол хэрэглүүр болгож, хөөцөлдөж байгаа хэрнээ ашиглалтанд нь анхаарал хяналт муутай хандаж байна. Гадаадын зээл, тусламжийг нэгдсэн зохицуулалттайгаар нэг банкаар дамжуулан ашиглавал үр ашиг дээшлэх магадлалтай.

6. Татвар, төсөв, мөнгө зээлийн механизм нь төрөөс эдийн засгийг зохицуулах гол арга нь болох ёстой. Цаашдаа татарын тогтолцоог улам боловсронгуй болгож, тогтворжуулах, дарамтыг харьцангуй

бууруулах зарчмын хандлага нь засгийн газрын санхүүгийн бодлогын гол асуудал юм. Өөрөөр хэлбэл төсвийн ачааллыг бууруулах нь эдийн засгийн өсөлтийг урамшуулах чухал хүчин зүйл. Татварын талаар анхаарвал зохих зүйлүүд:

- Юуны урьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын одоогийн мөрдөж байгаа хувь хэмжээг нэг шатлалд оруулж, ногдуулах хувь хэмжээг бууруулах;

Энэ өөрчлөлт хийх явдал нь эцэстээ татвар төлөгчдийн идэвхийг сэргээж, урамшуулах болно. Үүнийг яаралтай хийхгүй бол татварын тогтолцооны дотоод харьцаанд зохисгүй байдал бий болгохын зэрэгцээ татвар төлөгч аж ахуйн нэгжүүдийн ашиг сонирхол, идэвхид муугаар нөлөөлнө. Төр засгийн татварын бодлого нь нийгмийн өргөн давхаргад тааламжтай байх, ялангуяа үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хувийн сектор, жижиг бизнесийг дэмжсэн байвал зохино.

Татварыг цуглуулах бодит боломжтой уялдуулан төрийн санхүүгийн нөөцийн эрэлт шаардлагыг хангахад төсөв баримжаалах нь чухал юм. Төсвийн зарлага системтэй шинэчлэлд төдийлөн өртөөгүй өдий хүрлээ. Зарлагын бүрдүүлэлт нь нухацтай боловсрогдсон эдийн засаг, нийгмийн чиг баримтлал, улс орны тогтвортой хөгжлийн стратегийн чиглэлтэй нягт уялдах ёстой.

Дэлхийн болон дотоодын эдийн засгийн конъюнктурын хэлбэлзлээс манай улсын санхүүгийн тогтолцооны хамаарлыг урьдчилан багасгах, эдийн засагт өрийн ачааллыг бууруулах үүднээс төсвийн зарлагын бүрдүүлэлт, хуваарилалтыг шинэчилвэл зохистой. Ингэхгүйгээр төсвийн балансжилтанд хэзээ ч хүрэхгүй, төсөв ямар ч цаг үеийн аятай биш тохиолдлоос ямагт хамааралтай байх болно.

7. Мөнгө-зээлийн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа, үйлчилгээг эрс сайжруулах шаардлага хурц тавигдаж байна. Банкны үйл ажиллагаа эдийн засгийн хөгжлийн нэн чухал хүчин зүйл. Нэг ёсонд "цусны эргэлт"-ийн тогтолцоо нь юм.
  - Юуны урьд банк бодит эдийн засагт шууд зохистой нөлөөлөх мөнгө-зээлийн зөөлөн бодлого явуулах ёстой. Банкны секторыг капиталжуулах, зохион байгуулалтыг сайжруулах, зээлийн эрсдлийн даатгалыг хөгжүүлэх замаар банкны тогтолцооны чадваржилт, тогтворжилтыг дээшлүүлэх.
  - Улсын хэмжээний клирингийн тогтолцоог боловсронгуй болгох дээр суурилж мөнгөн хөрөнгийн төлбөр-тооцооны үйлчилгээг шуурхай болгох, арилжааны банкууд аж ахуйн нэгжид зээлийн гэрээгээр зээл олгох ажлын зохисгүй гажуудал, хүнд суртлыг арилгах, харилцан итгэлцэл хүлээсэн, найдвартай зээлдэгчдэд урамшуулал үзүүлэх, зээлийн баталгааг сайжруулах, эргүүлэн төлөлтийн сахилгыг чангалах. Зээлийн хүүг бууруулах боломж бий болсон, гэтэл бууралт удаан байна.
  - Арилжааны банкны санхүүг чадваржуулах, чанартай, найдвартай үйлчилгээний төлөө шударга өрсөлдөөнийг өрнүүлэх нь хамгаас чухал.

- Валютаар гүйцэтгэх төлбөр, гуйвуулгад хууль тогтоомжийг хатуу мөрдөх, арилжааны банкуудын хариуцлагыг эрс дээшлүүлж банкны үйл ажиллагааны хүрээнд валютын хяналтыг хүчтэй болгох.
  - Хадгаламжийн үйлчилгээг өргөтгөх, баталгааг сайжруулах үндсэн дээр иргэдийн банканд итгэх итгэлийг найдваржуулах,
  - Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний удирдлагыг эрс сайжруулж, банкнаас гадуур гүйгдэж байгаа мөнгөний урсгалыг багасгах, шийдвэртэй арга хэмжээ авахгүй бол одоогийн байдлаар үргэлжилвэл улс орны эдийн засаг ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болно.
8. Банкны болон үнэт цаасны хөгжилтэй тогтолцоогүйгээр санхүүгийн ялангуяа капиталын зах зээл цар хүрээтэй хөгжиж чадахгүй. Ийм байдал манайд одоо ажиглагдаж байна. Хэрэв энэ хүрээний хоцрогдол удаан үргэлжилбэл урт, дунд хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр улам хомсдож, хадгаламж хуримтлалын ашиглалтын механизмын бүрдүүлэлт улам эрсдэлтэй, үр ашиг багатай өөр аргаар хэрэгжих болно. Мөн энэ үед хуримтлалын урамшуулал суларна. Үүний зэрэгцээ санхүүгийн нөөцийг үр ашигтай хуваарилах, дайчлах механизм болох зээлийг оролцуулан санхүүгийн зах зээлийн үүрэг үйлчлэлийг хүчтэй болговол эдийн засгийн өсөлтийг хангахад чухал нөлөө үзүүлэх болно.

#### **Ном зүй:**

1. С.В.Лаптев, Основы теории государственных финансов. М.,2001.
2. Д.Цэрэнпил, Санхүүгийн бодлого. УБ., 1999он.
3. Д.Цэрэнпил, Д.Тунгалаг, Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал. УБ., 2002 он.

Төрийн захиргаа, удирдлагын академийн  
Докторант Г. Оюунцэцэг

### **Тахир дутуу иргэдийг хамгаалах механизмыг боловсронгуй болгоё**

*Төр, засгаас үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн ахуй нөхцлийг сайжруулах, эмчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар тахир дутуу иргэдийн тоог тогтвортой өсөхөөс сэргийлэх асуудал хурцаар тавигдаж байна. Судалгааны дүнгээс үзэхэд дэлхийн хүн амын 10 хувь нь тахир дутуу иргэд байгаа ба Монгол улсад 100 гаруй мянган тахир дутуу иргэд бүртгэгдээд байна. Манай улсад тахир дутуу иргэдийн талаар авч явуулж байгаа бодлого нь тусламж үзүүлэх, нөхөн олговор олгохоор хязгаарлагдаж байгаа бөгөөд тэдний онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх талаар туйлын бага байна. Ер нь нэгэнт тахир дутуу болсон иргэдэд үзүүлэх хамгийн гол тусламж бол нөхөн сэргээх эмчилгээ гэж үздэг юм байна. Гэтэл манай оронд нөхөн сэргээх эмчилгээний түвшин туйлын доогуур, тахир дутуу иргэдийн дөнгөж 5 орчим хувийг л дахин хөдөлмөрийн чадвартай болгож байна гэсэн тооцоо гарч байна. Иймээс судлаач тахир дутуу иргэдийн халамж үйлчилгээг сайжруулах талаар төр, нийгмээс зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай зарим арга хэмжээнүүдийн талаар өөрийн санал, дүнэлтээ энэхүү ажилд дэвшүүлсэн байна.*

Дэлхийн аливаа улс оронд бие эрхтний гэмтэл согогтой хүмүүс цөөнгүй байдаг бөгөөд, төр засгийн зүгээс нийгмийн онцгой халамж анхаарал тавьж, хөрөнгө санхүүгийн туслалцаа үзүүлж, эрхийг нь баталгаатай хамгаалах ёстой байдаг.

Эдгээр хүмүүс өөрсдийн амьдрал ахуйгаа бие даан аваад явах бололцоогоор туйлын хязгаарлагдмал байдаг. Иймд төр, засгаас үйлдвэрлэлийн болон хөдөлмөрийн ахуйн нөхцлийг сайжруулах, эмчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар тахир дутуу иргэдийн тоог тогтвортой өсөхөөс ямагт урьдчилан сэргийлэх асуудал хурцаар тавигдаж байна. Үүний зэрэгцээ тахир дутуу иргэдийн эрх ашгийг хамгаалан, тэдний дэмжлэг туслалцаа авах эрхийг найдвартай баталгаажуулж өгөх хэрэгтэй.

Олон улсын байгууллагуудын судалгааны дүнгээс үзвэл, дэлхийн хүн амын 10 хувь нь тахир дутуу иргэд байдаг юм байна. Манай улсад 100 гаруй мянган тахир дутуу иргэд бүртгэгдсэн бөгөөд жил бүр олон арван хүн тахир дутуу болж байна. Төрөлхийн тахир дутуу хүмүүс, суурь болон мэргэжлийн өвчтэй иргэд, үйлдвэрлэлийн болон ахуйн осолд орсон тахир дутуу иргэд ч энд хамаарч байна. Одоогоор манай улсад тахир дутуу тэтгэвэр авагч 30-аад мянган хүн байна.

Өнөөдрийг хүртэл тахир дутуу иргэдийн талаарх төрийн бодлого нь тусламж үзүүлэх, нөхөн олговор өгөх үндсэн дээр тулгуурлаж ирэв. Өөрөөр хэлбэл, улсаас тэдэнд тэтгэвэр, тэтгэмжийн хэлбэрээр мөнгөн тусламж олгож байгаа бөгөөд харин тэдний онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн халамжийн үйлчилгээ үзүүлэхэд туйлын бага анхаарч ирлээ. Тухайлбал, нисэх буудал, төмөр замын өртөө, эмнэлэг, үйлчилгээний газарт тахир

дутуу иргэнд зориулсан тэргэнцэргүй, бие засах газаргүй, тэргэнцэртэй хүн явах замгүй, эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулж, эмчлэх гэх мэт үйлчилгээ үгүйлэгдэж байна.

Нэгэнт тахир дутуу болсон иргэнд үзүүлэх хамгийн гол тусламж бол нөхөн сэргээх эмчилгээ хэмээн үзэж байна. Гэтэл манай оронд нөхөн сэргээх эмчилгээний түвшин туйлын доогуур байгаа тул тахир дутуу иргэдийн дөнгөж 5 орчим хувийг л дахин хөдөлмөрийн чадвартай болгодог гэсэн тооцоог мэргэжлийн хүмүүс хийжээ. Энэ үзүүлэлт нь хөгжилтэй орнуудынхаас үлэмж доогуур байна.

Тахир дутуу иргэдийн халамж үйлчилгээг сайжруулах, төр, нийгмээс үзүүлэх хайр ивээлийг үр дүнтэй, амьдралд зайлшгүй шаардлагатай асуудалд чиглүүлэхийн тулд дараах арга хэмжээг зохион байгуулмаар байна. Үүнд:

- Хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр иж бүрэн арга хэмжээ авч, тахир дутуу болох явдлаас урьдчилан сэргийлэх, нэн ялангуяа амьдрах, ажиллах орчны нөхцөл байдлыг сайжруулж хөдөлмөрийн аюулгүй, эрүүл нөхцлийг бүрдүүлэх, бүх төрлийн гэмтэл, бэртлээс урьдчилан сэргийлэх замаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалах;
- Эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүй, хөдөлмөрийн нөхөн сэргээх тогтолцоог шинэчлэх замаар өвчлөлт, бэртэлтийн үр дагаврыг багасгах, зарим тохиолдолд бүр арилгах, тахир дутуу иргэдэд бусад бүх иргэдийн нэгэн адил ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлэх, нийгэм улс төрийн амьдралд оролцох бололцоо олгох;
- Улсын болон орон нутгийн засаг захиргаа, иргэдийн хооронд, төрийн болон нийтийн байгууллагуудын хооронд тахир дутуу иргэдийг анхааран халамжлах талаар хамтран ажиллах үр нөлөө бүхий механизмыг бий болгох зэрэг асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндсийг бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн тахир дутуу иргэд нь холбогдох хууль тогтоомжоор олгосон тодорхой эрх зүйн баталгаатай байх ёстой. Одоогоор мөрдөгдөж буй тахир дутуу хүний нийгмийн хамгаалалын тухай хууль нь тахир дутуу иргэдийн амьдрал, үйл ажиллагааг аль болох бүрэн хамгаалах, төрийн дэмжлэг туслалцаа үзүүлэх арга хэмжээнүүдийг иж бүрэн тусгаж чадаагүй хэмээн үзэж байна.

Төрийн нийгмийн хамгааллын бодлого нь иргэнийг гэмтсэн, бэртсэний дараа нь халамжлах, дэмжих, туслах биш, харин тахир дутуу болох явдлаас урьдчилан сэргийлэхэд орших ёстой. Иймд төрийн бодлого, улсын хөтөлбөр, төслүүд нь экологи, эрүүл мэндийг хамгаалах, хүнд, хортой, аюултай ажлын байрыг багасгахад чиглэгдэх шаардлагатай. Гэтэл манай улсад тахир дутуу иргэдийн талаар бримталж байгаа бодлогын баримт бичиг болох “Тахир дутуу иргэдийн аж байдлыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” нь нэгэнт тахир дутуу болсон иргэдийг халамжлах, дэмжих, туслах зарим арга хэмжээг тусгах төдийгөөр хязгаарлагдсан байна. Энэхүү хөтөлбөрт тахир дутуу болохоос урьдчилан сэргийлэх төрийн бодлого үгүйлэгдэж байгааг зориуд тэмдэглэж хэлмээр байна.



Иймд иргэдийг тахир дутуу болгохгүй байх, болсон тохиолдолд нөхөн сэргээх эмчилгээ хийн хөдөлмөрийн чадвартай байлгах, бололцоогүйд хүрвэл нийгмийн халамжийн найдвартай үйлчилгээг тогтмол хүргэх чиглэлээр уг хөтөлбөрийг шинэчлэх нь зүйтэй.

Эдгээр асуудлыг цогцолбороор шийдвэрлэх тогтолцоо бий болгосноор дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд, Эмнэлэгийн үйлчилгээнд диспансерын буюу эмчлэн сэргийлэх хэлбэрийг хөгжүүлэх. Өвчлөлийн архаг хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тахир дутуу болохоос зайлсхийх, тахир дутуу болохын зовлонг нимгэлэх зорилго бүхий оношлогооны болон эмчилгээний төвүүдийн сүлжээг өргөтгөх хэрэгтэй. Эмчилгээг үргэлжлүүлэх тусгай сувиллын газар, сүлжээ бий болгож нөхөн сэргээх эмчилгээний өндөр үр ашиг бүхий шинэ арга хэмжээг нэвтрүүлмээр байна.

Эмнэлэгийн нөхөн сэргээлт гэдэг нь тахир дутуу иргэдэд амбулатори, эмнэлэг, гэр, стационар /суурин эмнэлэг/, эмнэлгийн тусгай төвүүдээр үзүүлэх эмнэлэгийн бүх төрлийн тусламжийг баталгаажуулна гэсэн үг юм. Хөдөлмөрийн чадварыг дээд зэргээр нөхөн сэргээх зорилгоор тахир дутуу болсны эхний 2-3 жилд эмчлэн сэргийлэх тусгай тогтолцоог бий болгох шаардлагатай.

Нөхөн сэргээлтийн төгсөлтийн шат нь тахир дутуу иргэнийг мэргэжлийн ажил хөдөлмөрт буцаан оруулах явдал юм. Энэ зорилгоор нөхөн сэргээх хөтөлбөрүүдийг боловсруулахдаа тэдэнд мэргэжлийн баримжаа олж авах, сургалтад хамрах, мэргэжлээ өөрчлөх, ажилд орох зэрэг тухайн тахир дутуу иргэний хэрэгцээ сонирхолыг иж бүрнээр тусгах нь чухал байна.

Тахир дутуу иргэд үйлдвэрийн газарт ажилд орох нь тэдний эрүүл мэндийн байдлаас хамаарна. Ингэхдээ ижил мэргэжил, зэрэглэлтэй эрүүл хүмүүсээс багагүй орлоготой байх явдлыг тэдэнд баталгаажуулж өгөхийг бодолцох хэрэгтэй.

Тахир дутуу иргэдийг ажлын байраар хангахын тулд энгийн үйлдвэрүүд дээр хамгаалагдсан тусгай орон тоонууд бий болгох, тусгай үйлдвэр, тасаг, цехийн сүлжээг хөгжүүлж (тахир дутуу иргэдийн нийгэмлэгүүдийн мэдэлд), үүний дотор эмнэлгийн нөхөн сэргээх албатай хослуулан ажиллуулах, богиносгосон ажлын өдөртэй байх нөхцлөөр тахир дутуу иргэдийг ажилд авах, ажлын цагаар нэмэлт завсарлагааны хуваарь гаргаж өгөх нь зүйтэй. Орон нутгийн засаг захиргаа нь өмчийн аль ч хэлбэрийн үйлдвэрт тодорхой тооны тахир дутуу иргэд ажиллуулах эрхтэй байх, үйлдвэрүүд энэ заалтыг зөрчсөн тохиолдолд тахир дутуу иргэдэд ажлын байр шинээр бий болгоход хүрэлцэхүйц хэмжээний мөнгөн торгууль оногдуулах эрхтэй байхыг хуульчлах хэрэгтэй. Монгол улсын хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлд ажил, үйлдвэрлэлийн онцлогт харшлахгүй тохиолдолд 50, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалын 3 түүнээс дээш хувийн орон тоонд тахир дутуу буюу одой хүнийг ажиллуулна гэсэн заалттай боловч хэрэгжилт нь туйлын хангалтгүй байна.

Тахир дутуу иргэдэд үзүүлэх нийгэм-ахуйн үйлчилгээнд гэрээр үзүүлэх тусламж гол байр үзүүлэх болно. Гэрийн нөхцөлд үзүүлэх тусламж нь тахир иргэдийн ашиг сонирхолд нийцэх бөгөөд өөрөө өөртөө үйлчлэх чадвар, хүрээлэн буй хүмүүстэйгээ энгийн тайван харилцах нөхцлийг бүрдүүлнэ.

Тахир дутуу иргэд, өндөр настанг суурин асрамжлах газрууд нь өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй хүмүүст туслах, тэдэнд эмнэлгийн нөхөн сэргэлт хийх хийх ажлыг гол чиглэлээ болгох ёстой юм.

Орон сууцны болон нийгмийн хэрэгцээний байшин барилга барих, суудлын болон нийтийн тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх явцад ч тахир дутуу иргэдийн эрх ашиг хуулиар хамгаалагддаг бөөгөөд нөхөн сэргээх болон нийгэм-ахуйн албадын цогцолбор бүхий орон сууцны барилга, нийгмийн халамжийн нутаг дэвсгэрийн төвүүдийг барьж байгуулах ажлыг өргөн хүрээтэй хийх шаардлагатай.

Тэдгээр төвүүд нь нийгэм-ахуйн үйлчилгээг эмнэлгээр болон гэрээр иж бүрэн үзүүлэх болно.

Онцгой ангиллын тахир дутуу иргэд болон өндөр настнуудад асрамжийн газрын сүлжээ ажиллуулах бөгөөд тэднийг түр болон байнга оршин суух, бололцоотой төлбөрөөр шаардлагатай тусламжаа авах бололцоогоор хангана.

Нийгмийн халамжийг хамгийн ихээр шаарддаг хэсэг бүлэг хүмүүс бол тахир дутуу хүүхдүүд юм. Тэдний амьдарч хүмүүжих хамгийн сайн, тааламжтай нөхцөл нь гэр орны нөхцөл учраас эцэг эх, асран хамгаалагчид бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх явдлыг баталгаажуулах хэрэгтэй. Ийм хүүхдүүдийг нийгэмшүүлэх зорилгоор тэднийг насанд хүрч гэр орноосоо болон асрамжийн газраас тусдаа амьдрах боломжтой болмогц нь орон сууц авах, ажилд орох эрхийг нь баталгаажуулж өгөх нь зүйтэй.

Тахир дутуу иргэдийн болон тэдний гэр бүлийнхний материаллаг хангамжийг сайжруулах зорилгоор олгох мөнгөн төлбөрийг нэмэгдүүлэх, биет үйлчилгээ, хөнгөлөлтийг нь ахиулах шаардлага тавигдаж байна. Тахир дутуу хүүхдийг асрамжилахад зориулан улсаас баталгаатай олгох мөнгөн төлбөр, төрөлхийн тахир дутуу хүүхдэд олгодог тэтгэмжийг амьдралын баталгаат доод түвшнээс багагүй байлгах шаардлагатай. Гэтэл манай улсын нийгмийн халамжийн сангаас төрөлхийн тахир дутуу хүүхдийг насанд хүрсэн үед нь 10 мянган төгрөгийн тэтгэмж олгож байгаа нь амьжиргааны баталгаажих түвшингээс бараг 2 дахин бага байна. Үндэсний статистикийн газрын тооцоолсноор, Улаанбаатар хотод амьжиргааны түвшин 19300 (Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор 17600 төгрөгөөр тогтоож өгч байна) төгрөг байна.

Тахир дутуу хүүхдийн гэр бүл, эцэг эх, тэднийг орлох хүмүүст үзүүлэх биет болон бусад хөнгөлөлт нь тахир дутуу иргэд, ялангуяа тахир дутуу хүүхдийг асрах, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах боломжийг олгох ёстой. Мөн татвар оногдуулах, нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлэх, нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх, орон сууц, эм тариа хэрэглэх зэрэгт нь тахир дутуу иргэдэд тусгай хөнгөлөлт үзүүлэх шаардлагатай. Мөн тахир дутуу иргэдэд зориулан хиймэл эд эрхтэн үйлдвэрлэж үйлчлэхэд онцгой анхаарал хандуулмаар байна.

Нийгмийн халамжийн байгууллагууд одоогийн хиймэл эрхтний үйлчилгээний зохион байгуулалтыг үндсээр нь шинэчлэн өөрчилж, тахир дутуу иргэдийг гэрээр нь үйлчлэх тогтолцоог хөгжүүлэн хиймэл эрхтэн

шаардлагатай иргэдийг илрүүлэн бүртгэлд авах ажлыг боловсронгуй болгохын зэрэгцээ мэс ажилбарын нөхөн сэргээх эмчилгээний шинэ шинэ аргуудыг нэвтрүүлмээр байна.

Хувийн авьяас сонирхол, нас, гэмтэл согогыг зэрэглэлээс нь хамааруулан тахир дутуу иргэдэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах талаар зохих санал санаачлагыг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Ялангуяа тахир дутуу хүүхдүүийн боловсролыг сайжруулах явдал онцгой ач холбогдолтой.

Түүнчлэн тахир дутуу хүмүүст нийгмийн халамж үзүүлж буй иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эдийн засгийн урамшууллын механизмын тусламжтайгаар хөөлөн дэмжих нь тулгамдсан асуудлын нэг болж байна.

Зарим гадаад орны туршлагаас үзэхэд, тахир дутуу иргэдийг жирийн нээлттэй хөдөлмөр эрхлэхэд нь туслах зорилгоор хөдөлмөр сургалтын төвүүдийг Засгийн газар болон бусад байгууллагууд ажиллуулдаг байна. Тахир дутуу иргэд хөдөлмөр сургалтын төвд ажилласнаар өөрсдийнхээ ур чадварыг нээх, ямар ажил хийж чадахаа олж мэдэхэд тустай хамгийн зөв арга юм. Дээрх төвүүдэд Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дараах 3 чиглэлээр дэмжиж, ажиллуулах нөхцлийг бүрдүүлдэг байна. Үүнд:

Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлт: Зарим байгууллага, компаниуд тусгай хөдөлмөр, үйлдвэрлэлийн төвд ажиллаж байсан ажилтнуудыг өөрийн байгуулагадаа ажиллуулахын тулд зайлшгүй ажлын ур чадвар, дадлагад нийцэх эсэхийг шалгах шаардлага гардаг. Хөдөлмөр, үйлдвэрлэлийн тусгай төвөөс жирийн байгууллагад орж ажиллах боломж маш цөөн хүнд олддог.

Энэхүү боломж шилжилтийг хийхэд туслах зорилгоор дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлт гэсэн ухагдахуун гарч байгаа юм. Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлт гэдэг нь, тахир дутуу иргэдийг ажлын байран дээр нь мэргэжил ээмших сургалтанд хамруулж дадлагажуулдаг. Энэхүү сургалтын үеэр мэргэжлийн хүмүүс тогтмол хамт ажиллана. Зарим ажилтнууд дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлтийн ачаар тодорхой хугацаагаар ажилласны дараа тухайн компанид байнгын ажилтан болдог. Энэхүү дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлт нь тахир дутуу иргэд нээлттэй хөдөлмөр эрхлэхэд нь туслах, ийм төрлийн хөдөлмөр эрхлэхэд тохиолдож буй хүндрэлийг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй арга зам мөн гэж үзэж байна.

Нээлттэй хөдөлмөр эрхлэлт: Хэрэв ажил олгогч бололцоо олговол зарим тахир дутуу иргэд бусдын дэмжлэггүйгээр нээлттэй хөдөлмөр эрхлэх чадвартай байдаг. Тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэх бололцоог нэмэгдүүлэхийн тулд Европын хэд хэдэн оронд болон Азийн орнуудад ажил олгогч нар өөрийн компанидаа тодорхой тооны ажлын байрыг тахир дутуу болсон хүмүүст зориулан бий болгох квотын системийг нэвтрүүлжээ. Хэрэв ажил олгогч энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд улсад тодорхой хэмжээний шимтгэл төлөх бөгөөд үүнийг тахир дутуу иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгод ашигладаг байна.

Энэхүү систем нь тахир дутуу иргэд хөдөлмөрийн нээлттэй зах зээлд орж ажиллахад нь туслах олон арга хэмжээнүүдийн зөвхөн нэгээхэн хэсэг юм.

Тахир дутуу иргэдийг ажиллуулснаар тухайн компанид ямарваа нэмэлт зардал, бусад хүндрэлтэй асуудлыг бий болгохоос зайлсхийхийн тулд ажил олгогчдод санхүүгийн болон бусад дэмжлэг туслалцааг үзүүлэх нь тахир дутуу иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бас нэг арга хэлбэр юм. Дэмжлэг туслалцаанд цалингийн татаас, татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, ажлын байрыг тахир дутуу иргэдэд зориулан олгох мөнгөн тусламж зэрэг байж болно.

Хувиараа хөдөлмөр эрхлэлт: Ихэнх хөгжиж буй орнуудад ажиллах хүчний дийлэнх нь хувиараа хөдөлмөр эрхлэдэг. Тахир дутуу хүмүүсийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн энэхүү хэлбэр нь нэлээд үр дүнгээ өгөх бололцоотой. Мэдээллийн технологи хөгжиж теле сүлжээ, цахилгаан худалдаа үүсч бий болсноор, ялангуяа хөдлөх эрхтэн нь тахир дутуу болсон иргэдэд нааштай бололцоо олгох нөхцөл бүрдэж байна.

Хувиараа бизнес эрхлэхийг хүссэн тахир дутуу иргэдэд санхүүгийн туслалцаа үзүүлэх хэлбэрийг олон оронд бий болгосон байна. Санхүүгийн туслалцаа олгох асуудлыг хөдөлмөр эрхлэлтийн алба эрхэлдэг. Гэвч тахир дутуу иргэдийн бизнесийг амжилттай явуулахад зөвхөн санхүүгийн туслалцаагаар хязгаарлах нь хангалтгүй юм. Тахир дутуу иргэд бизнес эрхлэх, удирдах, нягтлан бодох ур чадвар эзэмших шаардлагатай бөгөөд тэдэнд техникийн зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлэх, бүтээгдэхүүнийг нь зах зээлд худалдахад туслах, жижиг зээл авах, түүхий эд худалдан авах, бололцоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Эдгээр үйлчилгээний ихэнхийг хөдөлмөр эрхлэлтийн алба зохицуулна. Ялангуяа хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд шууд үзүүлэх үйлчилгээ, зарим нэг тодорхой үйлчилгээг хаанаас авч болох талаар мэдээлэл өгч чиглүүлэх бололцоотой.

Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын нэгээхэн хэсгийн талаар өөрийн судалгаа, шинжилгээний ажилтай холбогдуулан санал бодлыг нэмэрлэхэд ийм байна. Цаашид уг арга хэмжээг ажил хэрэг болгох талаар төр, захиргааны байгууллага, ялангуяа нийгмийн халамжийн асуудал хариуцсан яам, байгууллагууд онцгой анхаарна гэдэгт найдаж байна.